



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/182

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 7 иргэний нийт 0.2843га /2843м²/ газрыг 1 дүгээр, 2 аж ахуйн нэгж байгууллагын нийт 0.4284га /4284м²/ газрыг 2 дугаар хавсралтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дүгээр сарын 26-ны өдрийн
А/182 дүгээр захирамжийн 1 дүгээр
хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Эрх шилжүүлж байгаа иргэний овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэний овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Ар халиугчин овгийн Дашням Ичинхорлоо /РГ84090908/	Олхонууд овгийн Нэргүй Мөнхөө /РУ89122711/	6712015143	Гэр, орон сууцны хашааны газар	13-р баг 35-16 тоот	322	11	Аймгийн Засаг даргын 2019.10.31-ний өдрийн А/478 дугаар захирамжийн хавсралтын 22 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
2	Харуул овгийн Лозвой Эрдэнэбаатар /РЭ74071216/	Боржигон овгийн Лозвой Оюунбилэг /РЭ68060309/	6712017314	Гэр, орон сууцны хашааны газар	8-р баг Биржийн хашаа	270	25	Сумын Засаг даргын 2007.11.02-ны өдрийн №129 дүгээр захирамжийн хавсралтын 125 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
3	Хатгина овгийн Жамсран Цилхаа /РД50021715/	Барнууд овгийн Сумьяа Саранцэцэг /РД58081706/	6712008147	Гэр, орон сууцны хашааны газар	13-р баг 45-8 тоот	500	5	Аймгийн Засаг даргын 2012.10.25-ны өдрийн А/299 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 1 дэх заалт	Өвлөх эрхийн гэрчилгээгээр
4	Шир зан овгийн Доёд Цилхаа /РЕ60031574/	Борт овгийн Баттогтох Баярмаа /РГ95112600/	6712017319	Гэр, орон сууцны хашааны газар	7-р баг 29-9 тоот	681	25	Сумын Засаг даргын 2007.08.27-ны өдрийн №96 дугаар захирамжийн холбогдох хэсэг	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

5	Тогтох овгийн Чанцалваань Бадарч /СЭ62030118/	Барга овгийн Пунцаг Сэлэнгэ /РД77022818/ Солонго овгийн Хиагт Сувд-Эрдэнэ /РК78041801/	6712014284	Худалдаа, нийтийн үйлчилгээ ний газар	3-р баг 1- 216 тоот	799	2	Аймгийн Засаг даргын 2019.12.09-ний өдрийн А/569 дүгээр захирамжийн хавсралтын 1 дэх заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
6	Өвөг овгийн Бямбажав Бат- Очир /РЭ85110473/	Өвөг овгийн Бямбажав Очирбат /РЭ79110179/	6712012402	Худалдаа, нийтийн үйлчилгээ ний газар	8-р баг Даваадорж-3 307 тоот	237	25	Аймгийн Засаг даргын 2017.04.21-ний өдрийн А/234 дүгээр захирамжийн хавсралтын 2 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
7	Улаан хуулар овгийн Пүрвээ Амгаланбаатар /РЭ81020112/	Урианхай овгийн Бат-Очир Идэрбаатар /РЭ86022310/	6712017365	Автомаши ны гараж	8-р баг 17 дугаар байрны зүүн талд	34	3	Аймгийн Засаг даргын 2010.10.01-ний өдрийн А/355 дугаар захирамжийн хавсралтын 12 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Нийт газрын хэмжээ: 2843м²

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дүгээр сарын 26 -ны өдрийн
А/12 дүгээр захирамжийн 2 дугаар
хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Эрх шилжүүлж байгаа аж ахуйн нэгжийн регистр	Эрх шилжүүлэн авч байгаа аж ахуйн нэгжийн регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	“Хоймор нутгийн чулуу” ХХК /РД:4141121/	Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв /РД:4125207/	6712008688	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	13-р баг Олон гол трейдийн баруун талд	1942	29	Аймгийн Засаг даргын 2018.03.30-ны өдрийн А/227 дугаар захирамжийн хавсралтын 12 дахь заалт	Хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн
2	“ЕЕСС” ХХК /РД:2043688/	“Түмний цагаан хонь” ХХК /РД:4145879/	6712008721	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	13-р баг	2342	25	Аймгийн Засаг даргын 2011.03.22-ны өдрийн А/79 дүгээр захирамжийн хавсралтын 27 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Нийт газрын хэмжээ: 4284м²

-----oOo-----